


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-14 дүгээр долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **960** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 960 тохиолдлын 93% /892/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 7% /68/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/, Дорноговь /+2/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 267 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **14** ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2025.03.30 - 04.05)

2025 оны эпидемиологийн 14 дүгээр долоо хоногт угаарын хийн хордлогын **61** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 4%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 2 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-14 дүгээр долоо хоногт** нийт **257** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


130Эмнэлгийн
тусламж авч буцсан**127**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 14 дүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **17** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 23%-аар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 77%-аар өссөн байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 14 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	1	9	10
2	Эмийн хордлого	7	0	17
Нийт		8	9	17

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд тохиолдлын 67%-ийг 0-7 насны хүүхдүүд эзэлж байна. Шалтгаанаар авч үзвэл аяга таваг угаагч шингэн, бэх, цавуу, бензин зэрэг бүтээгдэхүүнд хордсон байна. **Санаатайгаар** эмийн бодисын хордлогод өртсөн тохиолдлуудыг авч үзвэл 26-аас 40 насныхан байна.

-оОо-